



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уртын гэгээ ОНӨААТҮГ 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/016/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2025 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа
Утас: 70518396
Аудитын менежер: М.Нарантуяа
Утас: 70512123
Аудитор: Б.Мөнхбамбар
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.1 Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	Error! Bookmark not defined.
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Төлбөрийн акт	9
5.2 Албан шаардлага	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.03.24 № 320

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бэлтгэн нийлүүлэгч компани руу шилжүүлсэн ажил гүйлгээний дүнгээс хувийн дансанд төсөв захирагч нь 2.4 сая төгрөг авсан, бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа тендер сонгон шалгаруулалт зарлахгүйгээр 178.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан худалдан авсан, хамаарал бүхий этгээдийн компанийн данс руу 157.1 сая төгрөг шилжүүлж ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй, тендер сонгон шалгаруулалт зарлах нөхцөл үүсгэхгүйгээр төсөвт өртгийг хувааж 272.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12, 34 дүгээр зүйлийн 34.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын болон батламж мэдэгдлийн түвшинд "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх", "толилуулга", "оршин байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 23/02 дугаар тогтоолоор баталж, тайлант онд 1,298.9 сая төгрөгийн нийт орлого, 1,143.3 сая төгрөгийн нийт зардалтай, 155.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,517.3 сая төгрөгийн орлого, 1,465.9 сая төгрөгийн зардалтай ажиллаж, 51.0 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Аудитын гол асуудал

Тайлант онд 329.3 сая төгрөгийн дулаан граж, 628.9 сая төгрөгийн үнэ бүхий офиссийн барилгыг өөрсдөө аж ахуйн аргаар барьж данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудал хэсэг

Уртын гэгээ ОНӨААТҮГ нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаггүй орон нутгийн төсвөөс татаас санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, тодруулга нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp is placed over a handwritten signature. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in black ink and is partially obscured by the stamp.

Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,036,330.10	5,760,399.95
1.1.2	Дансны авлага	14,009,932.13	20,011,974.33
1.1.6	Бараа материал	64,301,397.64	105,090,166.99
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	84,347,659.87	130,862,541.27
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,100,021,685.10	3,441,804,310.05
1.2.2	Биет бус хөрөнгө	2,007,359,500.00	17,977,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,107,381,185.10	3,459,781,810.05
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,191,728,844.97	3,590,644,351.32
2.1.1.1	Дансны өглөг	6,140,752.90	3,602,079.40
2.1.1.3	Татварын өр	1,590,365.00	5,711,288.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	7.82	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,678,839,697.60	4,013,872,962.26
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,686,570,823.32	4,023,186,329.66
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,686,570,823.32	4,023,186,329.66
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,505,158,021.65	(432,541,978.34)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,505,158,021.65	(432,541,978.34)
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	4,191,728,844.97	3,590,644,351.32

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	897,378,014.93	1,509,862,338.20
3	Нийт ашиг (алдагдал)	897,378,014.93	1,509,862,338.20
4	Түрээсийн орлого	0.00	7,472,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,006,340,368.69	1,458,015,095.03
11	Санхүүгийн зардал	123,900.00	100,755.16
12	Бусад зардал	0.00	2,107,200.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(109,086,253.76)	57,111,288.01
19	Орлогын татварын зардал	0.00	5,711,288.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(109,086,253.76)	51,400,000.01
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	0.00	51,400,000.01
24	Орлогын нийт дүн	0.00	51,400,000.01

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(243,180,915.19)	(243,180,915.19)
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	49,033,713.92	49,033,713.92
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(432,541,978.34)	(432,541,978.34)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(432,541,978.34)	(432,541,978.34)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	887,637,407.00	1,511,696,794.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,230,000.00	283,600,000.00
	Татаас, санхүүжилтын орлого	581,009,500.00	1,210,573,500.00
	Бусад мөнгөн орлого	296,397,907.00	17,523,294.00
1.2	Мөнгөн зарлага (-)	882,479,215.21	1,508,612,724.15
	Ажиллагчдад төлсөн	254,071,233.00	360,096,361.56
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	60,673,989.65	110,926,902.78
	Бараа материал худалдан авахад төлсөн	366,013,318.00	753,639,490.50
	Ашиглалтын зардалд төлсөн	136,508,338.10	168,215,477.30
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	35,694,465.00	60,245,189.00
	Татварын байгууллагад төлсөн	20,002,344.46	31,391,762.85
	Даатгалын төлбөрт төлсөн	540,000.00	2,004,025.00
	Бусад мөнгөн зарлага	8,975,527.00	22,093,515.16
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	3,084,069.85
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	308,000.00	0.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	308,000.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,100,000.00	3,360,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	2,100,000.00	3,360,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,100,000.00)	(3,360,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,750,191.79	(275,930.15)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,286,138.31	6,036,330.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,036,330.10	5,760,399.95

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	2	3	5	7
1	Бараа бүтээгдэхүүн борлуулалтын орлого	мян.төг		
	Ажил үйлчилгээ борлуулалтын орлого	мян.төг	16,500.00	16,138.80
	Түрээсийн орлого	мян.төг	4,950.00	7,472.00
	Санхүүжилтийн орлого	мян.төг	1,103,229.61	1,210,123.50
	Бусад орлого	мян.төг	174,240.00	283,600.00
	Нийт орлого	мян.төг	1,298,919.61	1,517,334.30
	Үүнээс: Цэвэр борлуулалт			
	үйл ажиллагааны бус орлого		174,240.00	293,253.70
2	Нийт зардал	мян.төг	1,126,033.70	1,460,223.00
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	1,101,392.31	1,458,015.00
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	172,885.91	59,319.30
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	155,597.60	51,400.00
5	Орон нутгийн өмчийн ноогдол ашиг			
6	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	29	34
7	Нийт цалингийн сан	мян.төг	292,452.00	360,096.30
8	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,107.70	882.59
9	Борлуулалтын /1 төгрөгт ноогдох зардал өссөн буурсан/		1.15	1.04
10	Хөрөнгө оруулалт			
#	Нийт авлага	мян.төг	-	-
	Үүнээс: найдвартай	мян.төг	-	-
	найдваргүй	мян.төг		
#	Нийт өглөг	мян.төг	1,100,695.30	4,023,186.30
	Үүнээс: Богоино хугацаат өр төлбөр	мян.төг	1,100,695.30	4,023,186.30
	Урт хугацаат өр төлбөр			

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 613.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс, 5.4 сая төгрөгт 2 төлбөрийн акт тогтоож, 607.8 сая төгрөг алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 2 албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Орон нутгийн өмчийн хөрөнгө түрээсэлсний төлбөр 7.5 сая төгрөгийн 40 хувь болох 3.0 сая төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлээгүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” , ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 74 тоот тогтоолын 2 дахь заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Бэлтгэн нийлүүлэгч компани руу шилжүүлсэн ажил гүйлгээний дүнгээс хувийн дансанд төсөв захирагч нь 2.4 сая төгрөг төвлөрүүлсэн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” заалтын тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

3.2.1 Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа тендер сонгон шалгаруулалт зарлахгүйгээр 178.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 “Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно.”, 34 дүгээр зүйлийн 34.1 “Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно.”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Хамаарал бүхий этгээдийн компанийн данс руу 157.1 сая төгрөг шилжүүлж ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2.3 Тендер сонгон шалгаруулалт зарлах нөхцөл үүсгэхгүйгээр төсөвт өртгийг хувааж 272.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.” заалтыг зөрчсөн байна.

3.2.4 Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа тендер сонгон шалгаруулалт зарлахгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авсан, хамаарал бүхий этгээдийн компанийн данс руу мөнгө шилжүүлсэн, тендер сонгон шалгаруулалт зарлах нөхцөл үүсгэхгүйгээр төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар

зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.”, 10.12 “Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно.”, 34 дүгээр зүйлийн 34.1 “Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно.”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” заалтыг тус тус зөрчсөн тул Нягтлан бодогч Д.Дэлгэрсайхан, Дарга Н.Энхжаргал нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлого дутуу төвлөрүүлсэн	1	3.0	1	3.0								
Бэлтгэн нийлүүлэгч компани руу шилжүүлсэн ажил гүйлгээний дүнгээс хувийн дансанд төсөв захирагч авсан	1	2.4	1	2.4								
тендер сонгон шалгаруулалт зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан	1	178.0			1	178.0						
Хамаарал бүхий этгээдийн компанийн данс руу мөнгө шилжүүлж ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй	1	157.1			1	157.1						
Тендер сонгон шалгаруулалт зарлах нөхцөл үүсгэхгүйгээр төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан	1	272.7			1	272.7						

албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн	2								2			
	7	613.2	2	5.4	3	607.8	-	-	2	-	-	-